

ҮАГ-ын АИТ-ЫН ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

2018.10.05.

АИТ-ын гишүүдийн хурал 14 цаг 30 минутад Засгийн газрын 4 байрны 412 тоот өрөөнд хуралдав.

Хуралд оролцсон:

1. МУЕА-ын зөвлөх, доктор (Ph.D), профессор, АИТ-ын тэргүүн А.Энхбат
2. Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөх, доктор (Ph.D) Б.Батбаяр
3. Монголын НББ-ийн хүрээлэнгийн тэргүүн, доктор (Ph.D), профессор Л.Дондог
4. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн гүйцэтгэх захирал, доктор (Ph.D) Л.Энх-Амгалан
5. Монголын Дауны холбооны УЗ-ийн гишүүн, доктор (Ph.D) Ш.Мөнхцэрэн
6. Монголын дотоод аудиторчуудын институтийн ерөнхийлөгч Л.Отгонбаяр
7. Аудитын боловсролын төв ТББ-ын гүйцэтгэх захирал А.Сүхбаатар
8. "Ил тод байдал сан" ТББ-ын гүйцэтгэх захирал, "Иргэд төсвөө хянана" иргэний нийгмийн сүлжээний зохицуулагч Д.Цэрэнжав
9. Дотоодын зөвлөх Д.Бүнчинсүрэн
10. СУГ-ын шинжээч, АИТ-ын нарийн бичгийн дарга З.Хонгорзул

Хэлэлцсэн асуудал:

1. Иргэний оролцоот гүйцэтгэлийн аудитын гарын авлагын төсөл
2. Аудитын үйл явц дахь иргэдийн оролцоог хангах стратеги
3. 2019 онд ТАБ-аас нэгдсэн удирдамжаар болон ҮАГ-ын гүйцэтгэх аудитын төлөвлөгөө
4. Бусад асуудал

Шийдвэрлэсэн нь:

Ажлын хэсгийн гишүүдийн 100%-ийн саналаар

- ТАБ-аас 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд "Газрын тухай хуулийн хэрэгжилт, үрдүн" аудитын нэрийн томъёололыг өөрчилж, нарийвчилж тодорхой болгох.
- ТАБ-аас 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зардалд аудит хийх талаар оруулах.
- Иргэний оролцоот гүйцэтгэлийн аудитын гарын авлагын төсөл болон Аудитын үйл явц дахь иргэдийн оролцоог хангах стратегийг алсын хараа, эрхэм зорилго, зорилт, үнэ цэнэ, төсөв гэсэн иж бүрдлийг бүрэн шингээсэн стратеги төлөвлөгөөний төсөл гарын авлага бэлтгэх.
- Аудитын тайланг иргэдэд ойлгомжтой, товчхон гаргаж байх.
- Аудитын сэдэв сонгоход иргэдийн саналыг авах, зөвлөмжийн биелэлтийг эргэн шалгахад иргэдийг оролцуулах, гаргасан тайлангаа иргэдийг оролцуулж сурталчлах.
- МУЕА-тай АИТ-ын гишүүдийг уулзах уулзалтыг зохион байгуулах

- ОНХС-ийн аудитад АИТ-мын гишүүдийг оролцуулах талаар тус тус санал нэгтэй дэмжив.